

**ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИД ЦЭРГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗЭРЭГ ОЛГОХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмын зорилго нь Зэвсэгт хүчний мэргэшсэн цэргийн алба хаагч /офицер, ахлагч/-д цэргийн мэргэжлийн зэрэг олгох, хамгаалах, ахиулах, бууруулах, хасах үед үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2. “Цэргийн мэргэжлийн зэрэг” гэж цэргийн алба хаагчийн эзэмшсэн цэргийн мэргэжлийн мэдлэг, дадлага, ур чадварын тусгайлсан шаардлага, шалгуур үзүүлэлтээр тогтоосон доод төвшинг хэлнэ.

1.3. Цэргийн мэргэжлийн зэргийн тусгайлсан шаардлагыг энэ журмын гуравдугаар бүлэгт зааснаар, шалгуур үзүүлэлтийг Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын тушаалаар тус тус тогтооно.

1.4. Цэргийн мэргэжлийн зэргийн тусгайлсан шаардлага, шалгуур үзүүлэлтийг ханган биелүүлсэн, эзэмшсэн цэргийн мэргэжлийнхээ зэргийн дагуу ажиллаж байгаа Зэвсэгт хүчний мэргэшсэн алба хаагчид цэргийн мэргэжлийн III, II, I зэрэг олгоно.

Цэргийн мэргэжлийн зэрэг олгох, ахиулах, бууруулах, хасах эрх зөвхөн Зэвсэгт хүчний Жанжин штабын даргад хадгалагдана.

1.5. Олгогдсон цэргийн мэргэжлийн зэрэг нь дараах хугацаанд хүчин төгөлдөр байна.

а. Офицер, ахлагч нарын:

Цэргийн мэргэжлийн III зэрэг – 3 жил (36 сар)

Цэргийн мэргэжлийн II зэрэг – 4 жил (48 сар)

Цэргийн мэргэжлийн I зэрэг – 5 жил (60 сар)

Мэргэжлийн зэрэгтэй цэргийн алба хаагч нь дээрх хугацаа дуусахаас өмнө мэргэжлийн зэргээ хамгаалах (ахиулах) шалгалт өгөх үүрэгтэй.

1.6. Цэргийн мэргэжлийн зэргийг шат дараалан олгоно. Үүнд:

- Мэргэжлийн зэрэггүй хүнд – III зэрэг
- Мэргэжлийн III зэрэгтэй хүнд – II зэрэг
- Мэргэжлийн II зэрэгтэй хүнд – I зэрэг

1.7. Цэргийн мэргэжлийн зэрэг эзэмшсэн цэргийн алба хаагчийн “Цэргийн алба хаагчийн сургалт, мэргэжлийн үйл ажиллагааны үнэлгээний дэвтэр”-т энэ тухай

тэмдэглэл хийж, ангийн тэмдэг дарж баталгаажуулах ба мэргэжлийн тухайн зэргийн энгэрийн тэмдэг гардуулж, мэргэжлийн зэргийн нэмэгдэл олгоно.

1.8. Офицер, ахлагч, гэрээт цэргийн алба хаагч хэд хэдэн мэргэжлээр цэргийн мэргэжлийн зэрэг эзэмшиж болно. Энэ тохиолдолд эзэмшсэн мэргэжлийн зэрэг бүрийн тухай “Цэргийн алба хаагчийн сургалт, мэргэжлийн үйл ажиллагааны үнэлгээний дэвтэр”-т тэмдэглэл хийх ба зөвхөн хамгийн дээд зэргийн мэргэжлийн зэргийн тэмдэг хэрэглүүлж, нэмэгдэл олгоно.

Хоёр. Мэргэжлийн зэргийн шалгалтын комисс

2.1. Цэргийн мэргэжлийн зэргийн шалгалтын комисс нь төв, салбар ба анги байгууллагын байна.

2.2. Мэргэжлийн зэргийн шалгалтын төв комиссыг Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын тушаалаар мэргэжлийн өндөр зэрэгтэй, магистраас доошгүй боловсролын зэрэгтэй 9-11 хүний бүрэлдэхүүнтэй 4 жилийн хугацаагаар томилно.

Төв комисс нь дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэнэ.

2.3. Төв комисс нь дараахь үүргийг хэргэжүүлнэ.

2.3.1. Мэргэжлийн зэргийн салбар болон ангийн комиссын үйл ажиллагааг удирдаж чиглүүлэх;

2.3.2. Цэргийн алба хаагчдад мэргэжлийн зэрэг олгуулах тухай салбар комиссын тодорхойлолт, холбогдох баримт бичгийг хянаж, дүгнэлт гаргах,

2.3.3. Мэргэжлийн зэргийн шалгалт явуулах хугацаа, журмыг тогтоох;

2.3.4. Мэргэжлийн зэргийн шалгалт явуулах асуулт, бодлого, дасгал, сорил, даалгавар, нормативыг тогтоох, салбар комиссын боловсруулсан дээрх баримт бичгийг батлах;

2.3.5. Зэвсэгт хүчний Жанжин штаб, түүний харъяа анги, командлал, бусад удирдах байгууллагын бие бүрэлдэхүүний болон мэргэжлийн I зэргийн шалгалтыг зохион байгуулж явуулах;

2.3.6. Мэргэжлийн зэрэг олгох, хамгаалсныг баталгаажуулах, ахиулах, бууруулах, хасах тухай санал боловсруулж, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргад танилцуулан шийдвэрлүүлэх;

2.3.7. Шаардлагатай гэж үзвэл хяналтын шалгалт явуулах.

2.4. Мэргэжлийн зэргийн салбар комиссыг төрлийн цэргийн командлагч, ҮБХИС-ийн захирлын тушаалаар, мэргэжлийн өндөр зэрэгтэй, магистраас доошгүй зэрэгтэй 7-9 хүний бүрэлдэхүүнтэй 3 жилийн хугацаатай томилно.

Салбар комисс нь дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэнэ.

2.5. Салбар комисс нь дараахь үүргийг хэргэжүүлнэ.

2.5.1. Мэргэжлийн зэргийн ангийн комиссын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх;

2.5.2. Мэргэжлийн зэргийн тусгайлсан шаардлагыг хангасан цэргийн алба хаагчийн тухай ангийн комиссын тодорхойлолт, материалыг хянан дүгнэлт гаргах, шаардлагатай тохиолдолд хяналтын шалгалт явуулах;

2.5.3. Мэргэжлийн III, II зэргийн шалгалт явуулах асуулт, бодлого, дасгал, сорил, даалгавар, нормативыг тогтоох саналаа төв комисст өргөн барьж батлуулах;

2.5.4. Харъяа анги байгууллагын цэргийн алба хаагчийн мэргэжлийн III, II зэргийн шалгалтыг зохион байгуулж явуулах;

2.5.5. Мэргэжлийн зэргийн шалгалтыг амжилттай өгсөн цэргийн алба хаагчдын мэргэжлийн зэрэг олгох, хамгаалсныг баталгаажуулах, ахиулах, тэнцээгүй цэргийн алба хаагчийн мэргэжлийн зэргийг бууруулах, хасах саналаа төв комисст өргөн мэдүүлэх.

2.6. Мэргэжлийн зэргийн ангийн комиссыг ангийн захирагчийн тушаалаар, мэргэжлийн өндөр бэлтгэлтэй, боловсролын бакалавраас доошгүй зэрэгтэй 5-7 хүний бүрэлдэхүүнтэй томилно. Тэр нь дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэнэ.

2.7. Мэргэжлийн зэргийн ангийн комисс нь дараахь үүргийг биелүүлнэ.

2.7.1. Мэргэжлийн зэргийн шалгалтанд орохыг хүссэн цэргийн алба хаагчдад сургалт, арга зүйн туслалцаа үзүүлэх;

2.7.2. Мэргэжлийн зэрэг эзэмших, баталгаажуулах, ахиулахыг хүссэн цэргийн алба хаагчийн өргөдөл, бусад холбогдох материалыг хүлээн авч бүрдүүлэн салбарт комисст танилцуулах;

2.7.3. Мэргэжлийн зэргээ баталгаажуулбал зохих хүмүүсийн судалгаа хийж, тооцоо хөтлөх;

2.7.4. Мэргэжлийн зэргийн шалгалтад орохыг хүссэн цэргийн алба хаагчдын мэргэжлийн зэргийн тусгайлсан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан байдлыг урьдчилан шалган тогтоох;

2.7.5. Мэргэжлийн зэргийн шалгалтыг хүлээн авахад бэлэн болсон тухай салбарт комисст мэдэгдэх.

Гурав. Мэргэжлийн зэрэгтэн болон зэргийн шалгалтанд орохыг хүсэгчдэд тавигдах шаардлага

3.1. Мэргэжлийн зэрэгтэн болон зэргийн шалгалтад орохыг хүсэгч нь дараахь шаардлагыг хангасан байна.

3.1.1. Цогцолбор болон командлалын шалгалтад “B”-ээс доошгүй үнэлгээтэй шалгагдсан байх;

3.1.2. Алба хаасан хугацаа (жилээр):

Ангилал	III	II	I
Ахлагч	3	7	9
Салааны захирагч, түүнтэй дүйцэх	2	3	4
Рот (батарея)-ын захирагч, түүнтэй дүйцэх	4	6	8
Батальон (дивизион)-ын захирагч, түүнтэй дүйцэх	6	8	10
Хороо (бригад)-ны захирагч, түүнтэй дүйцэх	8	10	12

Цэргийн дээд командлалын ажилтан	10	12	14

3.1.4. Төрийн алба хаагчийн жилийн үйл ажиллагааны үр дүнгийн гэрээний биелэлт - “А”,

3.1.5. Гадаад хэлний бэлтгэл:

Офицер - дунд шат,
 Ахлагч - бэлтгэл дунд шат,
 Гэрээт цэрэг - анхан.

3.1.6. Хувийн зэвсгээр буудах дадлага -“В”,

3.1.7. “Цэргийн алба хаагчийн бие бялдрын бэлтгэлжилтийн шалгуур үзүүлэлт – “В”, стандарт хангасан,

3.1.8. Мэргэжлийн бэлтгэл – “А”.

3.2. Цэргийн мэргэжлийн онцлог, мэргэжлийн зэргийн төвшингөөс хамаарч, мэргэжлийн зэргийн төв комиссийн санал, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын шийдвэрээр тусгайлсан нэмэгдэл шаардлага тавьж болно.

Энэ тухай шийдвэрээ мэргэжлийн зэргийн шалгалт эхлэхээс 2 сараас доошгүй өмнө мэргэжлийн зэргийн салбар ба ангийн комисс, мэргэжлийн зэрэг эзэмших, ахиулахыг хүсэгчид мэдэгдэнэ.

Дөрөв. Мэргэжлийн зэрэг олгох, хамгаалуулах, ахиулах шалгалт явуулах

4.1. Цэргийн мэргэжлийн зэрэг эзэмших, зэргээ хамгаалах, ахиулахыг хүссэн цэргийн алба хаагч нь мэргэжлийн зэргийн шалгалт эхлэхээс 45-аас доошгүй хоногийн өмнө доорхи материалыг бүрдүүлэн ангийн комисст ирүүлнэ. Үүнд:

- Өргөдөл;
- “Цэргийн алба хаагчийн сургалт, мэргэжлийн үйл ажиллагааны үнэлгээний дэвтэр”-ийн хуулбар;
- Мэргэжлийн зэргийн шалгалтанд оруулах тухай шууд захирах даргын /хүснэгтэн/ тодорхойлолт.

4.2. Мэргэжлийн зэргийн ангийн комисс нь мэргэжлийн зэргийн шалгалтанд орохыг хүсэгчийн материалыг хүлээн аваад дараахь үүргийг биелүүлнэ.

4.2.1. Мэргэжлийн зэргийн шалгалтад орохыг хүсэгчийн материалын бүрдэл үнэн зөвийг хянан магадлах;

4.2.2. Түүний мэргэжлийн зэрэгтэнд тавигдах тусгайлсан шаардлага, ур чадварын төвшинг урьдчилан шалгаж, тэр нь мэргэжлийн зэргийн болзлыг хангаж байгаа эсэхийг тогтоох;

4.2.3. Мэргэжлийн зэрэгтэнд тавигдах тусгайлсан шаардлага, ур чадварын төвшингийн болзлыг биелүүлсэн хүний материалыг урьдчилсан шалгалтын дүнгийн хамт мэргэжлийн зэргийн салбар комисст илгээх;

4.2.4. Мэргэжлийн зэргийг бууруулах, хасах санал оруулах;

4.2.5. Салбар комиссоос мэргэжлийн зэргийн шалгалт явуулах нөхцөл, бололцоог бүрдүүлэх.

4.3. Салбар комисс нь мэргэжлийн зэрэг эзэмших, хамгаалах, ахиулахыг хүсэгчийн материалыг хүлээн аваад дараахь үүргийг биелүүлнэ.

4.3.1. Цэргийн мэргэжлийн I зэрэг эзэмших, хамгаалахыг хүсэгчийн материалыг магадлан шалгаад, төв комисст шилжүүлэх;

4.3.2. Цэргийн мэргэжлийн III, II зэрэг олгох, хамгаалуулах шалгалтын материал (асуулт, бодлого, дасгал, сорил, даалгавар, норматив)-ыг цэргийн мэргэжил тус бүрээр боловсруулж, төв комиссын даргаар батлуулах;

4.3.3. Цэргийн мэргэжлийн III, II зэрэг олгох, хамгаалуулах шалгалтыг зохион байгуулан явуулах;

4.3.4. Цэргийн мэргэжлийн зэрэг олгуулах, бууруулах, хасах саналаа холбогдох материалын хамт төв комисст хүргэх.

4.4. Төв комисс нь Зэвсэгт хүчний Жанжин штаб, командлал, бусад удирдах байгууллагын ажилтан болон цэргийн мэргэжлийн I зэрэг олгох, хамгаалуулах шалгалтыг зохион байгуулан явуулна.

4.5. Мэргэжлийн зэргийн шалгалтанд орогч бүх тусгайлсан шаардлага, тухайн зэргийн шалгуур үзүүлэлтийг “Сайн”-аас доошгүй үнэлгээтэй биелүүлсэн тохиолдолд түүнийг шалгалтанд тэнцсэнд тооцно.

4.6. Цэргийн мэргэжлийн зэрэг олгох, хамгаалуулах, ахиулах шалгалтын материалыг доод шатны комиссоор бэлтгүүлэх, түүнийг нэгээс илүү удаа шалгалтанд ашиглахыг хориглоно. Шалгалтын материал нь уг шалгалтыг эхлэх хүртэл чанд нууцлагдана.

4.7. Цэргийн мэргэжлийн зэргээ хамгаалах шалгалтыг тухайн мэргэжлийн зэрэг олгох шалгалттай хамт явуулж болно. Шалгуулагч уг мэргэжлийн зэргийн тусгайлсан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа тохиолдолд түүнийг мэргэжлийн зэргээ хамгаалсанд тооцож, энэ журмын 1.5-д заасан хугацаагаар сунгана.

4.8. Мэргэжлийн зэргийн шалгалтыг ЗХЖШ-ын цогцолбор шалгалттай хамтатган зохион байгуулж болно.

4.9. ЗХЖШ-ын цогцолбор шалгалтын үед төв, салбар комиссын 2-оос доошгүй гишүүн, мэргэжлийн зэргийн ангийн комиссыг оролцуулан мэргэжлийн зэргийн шалгалтыг зохион байгуулж болно.

Тав. Мэргэжлийн зэргийг бууруулах, хасах

5.1. Дараахь тохиолдолд цэргийн алба хаагчийн мэргэжлийн зэргийг бууруулна.

5.1.1. Эзэмшсэн мэргэжлийн зэргээ хамгаалах шалгалтад тэнцээгүй боловч доод шатны зэргийн болзлыг биелүүлж байгаа;

5.1.2. Мэргэжлийн алдаа гаргасан.

5.2. Дараахь тохиолдолд цэргийн алба хаагчийн мэргэжлийн зэргийг хасна.

5.2.1. Эзэмшсэн мэргэжлийн зэргийнх нь хүчин төгөлдөр байх хугацаа дууссан боловч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр мэргэжлийн зэргээ хамгаалах шалгалтанд ороогүй;

5.2.2. Эзэмшсэн мэргэжлийн зэргээ хамгаалах шалгалтад тэнцээгүй, доод шатны зэргийн болзлыг хангахгүй байгаа;

5.2.3. Мэргэжлийн ноцтой алдаа гаргаснаас хүний амь нас, эрүүл мэнд, эд материалын үлэмж хохирол учруулсан;

5.2.4. Шүүхээр шийтгэгдсэн.

5.3. Цэргийн мэргэжлийн зэрэгтэн командлалын болон цогцолбор шалгалтаар “Дунд”, түүнээс доош үнэлгээтэй шалгагдсан нь түүний мэргэжлийн зэргийг бууруулах, хасах үндэслэл байж болно.

5.4. Цэргийн мэргэжлийн зэрэг нь буурсан, хасагдсан цэргийн алба хаагч түүнийг ахиулах, сэргээх хүсэлт гаргаж болно. Энэ тохиолдолд мэргэжлийн зэргийг ахиулах, шинээр олгох журмыг баримтлана.

Зургаа. Цэргийн мэргэжлийн зэрэгтэнд үзүүлэх хөнгөлөлт, урамшуулал

6.1. Цэргийн мэргэжлийн зэрэгтэнд Монгол Улсын Засгийн газраас тогтоосон цэргийн мэргэжлийн зэргийн нэмэгдэл олгоно.

6.2. Цэргийн мэргэжлийн зэрэгтэй цэргийн алба хаагчийг албан тушаал дэвшүүлэх, албан тушаалын зэрэглэлийн цол олгох, сургууль, дамжаанд сургах, гадаад ажиллагаанд оролцуулах, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд урьтал болгоно.

Долоо. Цэргийн мэргэжлийн зэрэгтний тооцоо, судалгаа

7.1. Цэргийн мэргэжлийн зэрэгтний тооцоо, судалгааг Зэвсэгт хүчний Жанжин штаб, командлал, анги, байгууллагын сургалт хариуцсан нэгж, албан тушаалтан гардан хариуцаж хөтөлнө.

7.2. Цэргийн мэргэжлийн зэрэгтний тооцоо, судалгаа цахим, бичмэл хэлбэртэй байна.

7.3. Цэргийн мэргэжлийн зэрэгтний тооцоо, судалгаа, тэднийг бэлтгэх талаар гүйцэтгэсэн ажлын тайлан, авах арга хэмжээний талаархи саналаа төв комисс Зэвсэгт хүчний Жанжин штабын даргад, салбар комисс нь цэргийн командлагчид, ангийн комисс захирагчдаа жилд 2 удаа илтгэж байна.